| 1. | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх | Компанийн захирал Байгаль орчны мэргжилтэн | Байгаль орчны бодлого хөтөлбөр, хяналт шинжилгээ хийх журам, хог хаягдлын цуглуулах, хадгалах ажлын тухай заавар журмуудыг захирлаар батлуулж, ажилчдад танилцуулан дагаж мөрдөн ажиллаж байна. |
| 2. | Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтэд хяналт тавих | | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавьж ажилллаcан. |
| 3. | Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон Галуут сумын ЗДТГ-т хүргэн өгч байх | | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан болон тус оны нөхөн сэргээлт, нийгмийн хариуцлагын тайланг хүргэн танилцуулдаг. |

*Хүснэгт 9 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нийт зардал*

| Д.д | Зардлын утга | Нийт зардал, мян.төг |
|---|---|---|
| 1 | Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний ажлын зардал | **700.0** |
| 2 | Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний зардал | **900.0** |
| 3 | Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал | **600.0** |
| 4 | Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал | **800.0** |
| 5 | Хог хаягдлын менежментээр хийгдсэн ажлын зардал | **3 000.0** |
| 6 | Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний зардал | **1 000.0** |
| 7 | Нөхөн сэргээлтийн ажлын зардал | **7 000.0** |
| 8 | Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн зардал | **4 000.0** |
| 9 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал | **3 160.0** |
| 10 | Удирдлага зохион байгуулалт | **1 800.0** |
| 11 | БОМТ хэрэгжилт тайлагнах | **1 000.0** |
| | **2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн** | **23 960.0** |

# 11. ДҮГНЭЛТ

Биологийн нөхөн сэргээлтийг ***6.7 га***-д бэлчээрийн зориулалтаар олон наст ургамлуудаар тариалалт хийсэн байна. Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ажлаар орон нутгаас зааж өгсөн ***2.0 га*** талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 1000 ш улиас мод тарих, арчлах, цэнэг усалгаа хийх ажлыг зохион байгуулж ажиллаа..

БӨӨН ЦАГААН-ОРОГ НУУРЫН
САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 03 сарын 07 өдөр — Дугаар А/08 — Нөмгөн

"Империал Гоулд Майнинг" ХХК-д ус ашиглах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Усны тухай хуулийн 17 дугаар зүйл 17.1.10 дахь заалт, 28 дугаар зүйл 28.6 дахь заалт , 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн Хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн Е-2501-000010 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Баянхонгор аймгийн Галуут сумын нутаг дахь "Хүүшийн ам " нэртэй MV-015643 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай алтны шороон ордод унд ахуй, технологийн хэрэгцээнд 2025 онд нийт 145,362 шоо метр усыг ашиглахыг "Империал Гоулд Майнинг" ХХК-д зөвшөөрсүгэй.

2.Ус ашиглах гэрээг байгуулж дүгнэх, эрх үүргийг мөрдөж ажиллахыг Уул уурхай, эрчим хүчний ус ашиглалт хариуцсан мэргэжилтэн (Ц.Доржнамжин), "Империал Гоулд Майнинг" ХХК-ий захирал (М.Энхтайванбаатар)-д тус тус даалгасугай.

3.Холбогдох хуульд заасан ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг чанд биелүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллах, холбогдох мэдээ тайлан, гэрээний биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 01-ний дотор ирүүлэхийг "Империал Гоулд Майнинг" ХХК-ий захирал (М.Энхтайванбаатар)-д даалгасугай.

4.Усны ашиглах боломжит нөөц, ус ашиглалтын байдал, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ус ашиглах зөвшөөрөл, ус ашиглах гэрээний хамт аймгийн Татварын хэлтэс, Галуут сумын Засаг даргын Тамгын газарт тус тус хүргүүлж, төлбөр хураамжийн төвлөрүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг Усны чанар экологи, төлбөрийн асуудал, Газрын доорх усны нөөц, хяналт шинжилгээ хариуцсан мэргэжилтэн (Л.Энхтогтох)-д үүрэг болгосугай.

ДАРГА Б.НЯМ-ОЧИР

C:\Users\2024 он\... .docx

БАТЛАВ
ДАРГА Б.НЯМ-ОЧИР

БАТЛАВ
"ИМПЕРИАЛ ГОУЛД МАЙНИНГ"
ХХК-ИЙ ЗАХИРАЛ
М.ЭНХТАЙВАНБААТАР

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2025 оны 03 дугаар сарын 10 | Дугаар 02 | Номгон

**НЭГ. Ерөнхий зүйл**

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.7, 29 дүгээр зүйлийн 29.1-дэх заалт, Монгол Улсын Засгийн Хэрэгжүүлэгч агентлаг Ус газрын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн Е-2501-000010 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/08 тоот тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн

Ус ашиглуулагчийг төлөөлж: Баянхонгор аймаг, 1-баг, Номгон, Голомт банктай байрны 404 тоот, Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны Уул уурхай, эрчим хүчний ус ашиглалт хариуцсан мэргэжилтэн Ц.Доржнамжин

Ус ашиглагчийг төлөөлж: Баянхонгор аймаг, Галуут сум, Сүмбэр 2-баг утас:99110777, Улсын бүртгэлийн дугаар:9011720069, регистрийн дугаар:6171788, "Империал Гоулд Майнинг" ХХК-ий захирал М.Энхтайванбаатар нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаатайгаар байгуулав.

**ХОЁР. Гэрээний нөхцөл**

2.1 Хүн ам, үйлдвэрийн хэрэгцээнд

2.2 Ашиглах усны хэмжээ – 145362.0м$^3$

2.2.1 ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл үйлчилгээнд - 8190.0м$^3$

2.2.2 Хүдэр боловсруулахад- 122880.0м$^3$

2.2.3 Зам талбайн тоосжилт дарахад – 4032.0 м$^3$

2.2.4 Биологийн нөхөн сэргээлтэнд ашиглах- 900.0 м$^3$

2.2.5 Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд-1000 м$^3$

2.2.6 Уурхайн өрөмдлөгт ашиглах – 8360 м$^3$

**2.3 Усны чанар найрлага:** Үйлдвэрийн болон унд ахуйн усанд гидрохимийн шинжилгээ хийлгэж, шинжилгээний хариуг улирал тутамд Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаанд ирүүлэх

**2.4 Усны эх үүсвэрийн байршил**

Унд ахуйн болон технологийн хэрэгцээний усыг уурхайн талбайд байрлах 2 гүний худгаас хангана.

Солбицол: Худаг 1. Байршил-100º00'35'', 46º25'46.''

Худаг 2. Байршил-100º08'38.5', 46º25'52.9'

**Дамжуулах байгууламж /шугам сүлжээний урт диаметр/:** Эргэлтийн усан сангаас элс угаах төхөөрөмж рүү ус 125WFB-220 маркийн динамик насосоор, элс угаах төхөөрөмжөөс хаягдлын усан сан руу 200S-95 маркийн динамик насосоор усыг шахдаг.

*Хавсралт 1 Ус ашиглах гэрээ, зөвшөөрөл*

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

# УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

Улаанбаатар хот

2025 оны 1 дүгээр сарын 16 -ний өдөр

Дугаар E-2501-000010

Утас: 265528, 265578

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

| | |
|---|---|
| Оноосон нэр: | Империал гоулд майнинг |
| Улсын бүртгэлийн дугаар: | |
| Регистрийн дугаар: | 6171788 |
| Захирал: | Энхтайванбаатар |
| Холбоо барих дугаар: | 99110777 |
| Факс : | |
| И-мэйл хаяг : | |

2. Төслийн нэр байршил

| | |
|---|---|
| Төслийн нэр: | Хүүшийн ам |
| Байршил: | Баянхонгор, Галуут, 2-р баг, Сумбэр |
| Харьяалагдах сав газар: | Бөөнцагаан нуур, Байдраг голын сав газар |
| Хамаарах салбар: | Уул уурхай |
| Төслийн дэлгэрэнгүй: | Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт MV-015643 тусгай зөвшөөрөл бүхий 106.51 га талбайд орших "Хүүшийн ам" алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл. |

3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр

Империал гоулд майнинг

4. Ажиллах горим, хүчин чадал

| Үргэлжлэх хугацаа | Ажиллах горим | Жилд ажиллах хоног | Хоногт ажиллах ажилчдын тоо | Хоногт ажиллах цаг |
|---|---|---|---|---|
| 1 | 2 ээлжээр | 300 | 179 | 20 |

5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ

| Ажлын нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Тайлбар |
|---|---|---|---|
| Хүдэр боловсруулахад ашиглах усны хэмжээ | 102400.0 | тонн | Баянхонгор аймгийн Галуут сумын Хүүшийн ам ордын 2025 оны уулын ажлын төлөвлөгөө, маягт-3, БОННҮТ-ын 43-44 хуудас. |
| Уурхайн өрөмдлөгт ашиглах | 836.0 | 100.0 тууш.метр | Баянхонгор аймгийн Галуут сумын Хүүшийн ам ордын |

*Хавсралт 2 Ус ашиглуулах дүгнэлт*

| Ажлын нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Тайлбар |
|---|---|---|---|
| усны хэмжээ | | | 2025 оны үүлын ажлын төлөвлөгөө, маягт-9.1. |
| Зам, талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ | 8400.0 | м2 | Баянхонгор аймгийн Галуут сумын "Хүүшийн ам"-ны алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн БОННҮТ-ын 44 хуудас. |
| Биологийн нөхөн сэргээлтэд ашиглах усны хэмжээ | 25000.0 | м2 | Баянхонгор аймгийн Галуут сумын Хүүшийн ам ордын 2025 оны үүлын ажлын төлөвлөгөө, маягт-10 |
| Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан болон тарих модны арчилгаа, усалгаанд ашиглах усны хэмжээ | 2000.0 | ш | Баянхонгор аймгийн Галуут сумын Хүүшийн ам ордын 2025 оны үүлын ажлын төлөвлөгөө, маягт-10, 2024 оны ус ашиглуулах дүгнэлт (2025 онд 1000 ш, 2024 онд 1000 ш) |
| Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ | 182.0 | хоногт 1 хүн | Баянхонгор аймгийн Галуут сумын Хүүшийн ам ордын 2025 оны үүлын ажлын төлөвлөгөө, маягт 3, 12-т 300 хоногт 182 хүн ажиллахаар тусгагдсан байна. |

## 6. Усны эх үүсвэр, нөөц, хоногт ашиглах хэмжээ

| Эх үүсвэр | Зориулалт | Усны нөөц (л) | Усны нөөц (м3) | Тайлбар |
|---|---|---|---|---|
| Гүний худаг | Унд ахуй | 2.0 | 172.8 | Усны газрын 2024.07.22-ны өдрийн E-2407-000071 дугаар Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтээр "Хүүшийн ам"-ны алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөлд шаардагдах 613.86 м3/хон усны хэрэглээг 12.0 л/сек (1,036.80 м3/хон) нийлбэр үндаргатай өөрийн эзэмшлийн 2 гүний худгаас хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй гэсэн байна. |
| Гүний худаг | Технологийн хэрэгцээнд | 10.0 | 864.0 | Усны газрын 2024.07.22-ны өдрийн E-2407-000071 дугаар Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтээр "Хүүшийн ам"-ны алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөлд шаардагдах 613.86 м3/хон усны хэрэглээг 12.0 л/сек (1,036.80 м3/хон) нийлбэр үндаргатай өөрийн эзэмшлийн 2 гүний худгаас хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй гэсэн байна. |

## 7.Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл

| | |
|---|---|
| Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан ААНБ : | **Ногоон эко мандала** |
| Холбоо барих : | **88107628** |
| Нэмэлт мэдээлэл : | |

## 8. Усны барилга байгууламжууд

| Барилга байгууламж | Хүчин чадал (м3) | Хэмжээ хийц |
|---|---|---|
| Усан сан | 45500.0 | Уурхайн урд хэсгийн уулын налуу газрыг хашиж 0.4 га талбайд 31,000.0 м3, 0.26 га талбайд 14,500 м3 багтаамжтай 2 тунгаах усан сан байгуулсан. |
| Усан сан | 40000.0 | Уурхайн урд хэсгийн уулын налуу газрыг хашиж 0.3 га талбайд 21,000.0 м3, 0.27 га талбайд 19,000 м3 багтаамжтай 2 эргэлтийн усан сан байгуулсан. |

## 9. Дамжуулах байгууламж

| Хаанаас (эхлэх цэг) | Хаана хүртэл (төгсгөлийн цэг) | Шугамын голч, мм | Дамжуулах шугамын урт, м |
|---|---|---|---|

## 10. Онцгой нөхцөл

- Усны тухай хуулийн 30.1.2-т заасны дагуу усны хэрэглээ хариуцсан ус ашиглалтын менежер ажиллуулах үүрэгтэй тул хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд ус ашиглуулах дүгнэлт гаргахгүй байхыг анхаарах;
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу усны шугам, хоолой бүрд баталгаажсан онлайн тоолуур суурилуулах;
- Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулахыг хориглоно;
- Голын хамгаалалтын бүсэд хөрс хуулалт, олборлолт явуулахыг хориглоно;
- Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа голыг хамгаалах арга хэмжээ авах, хөв цөөрөм байгуулах, татмын ойжуулалт хийх г.м;
- "Хаягдал ус. Ерөнхий шаардлага" MNS4943:2015 стандартын шаардлагад нийцүүлэн байгальд нийлүүлэх;

## 11. Усны зарцуулалт

| Ажлын нэр | Тоо Хэмжээ | Хэмжих нэгж | Усны хэрэглээ, м3 (Норм) | Гүйцэтгэх давтамж | Хэмжих нэгж | Нийт ашиглах усны хэмжээ, м3 | Хөнгөлөх усны хэмжээ м3 | Төлбөр тооцох усны хэмжээ м3 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хүдэр боловсруулахад ашиглах усны хэмжээ | 102400.0 | тонн | 4.0 | 1.0 | Удаа | 409,600.00 | 286,720.00 | 122,880.00 |
| Уурхайн өрөмдлөгт ашиглах усны хэмжээ | 836.0 | 100.0 туушметр | 10.0 | 1.0 | Удаа | 8,360.00 | 0.00 | 8,360.00 |
| Зам, талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ | 8400.0 | м2 | 0.002 | 240.0 | Хоног | 4,032.00 | 0.00 | 4,032.00 |
| Биологийн нөхөн сэргээлтэд ашиглах усны хэмжээ | 25000.0 | м2 | 0.004 | 9.0 | Удаа | 900.00 | 0.00 | 900.00 |
| Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан болон тарих модны арчилгаа, усалгаанд ашиглах усны хэмжээ | 2000.0 | ш | 0.05 | 10.0 | Удаа | 1,000.00 | 0.00 | 1,000.00 |

| Ажлын нэр | Тоо Хэмжээ | Хэмжих нэгж | Усны хэрэглээ, м3 (Норм) | Гүйцэтгэх давтамж | Хэмжих нэгж | Нийт ашиглах усны хэмжээ, м3 | Хөнгөлөх усны хэмжээ м3 | Төлбөр тооцох усны хэмжээ м3 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ | 182.0 | хоногт 1 хүн | 0.15 | 300.0 | Хоног | 8,190.00 | 0.00 | 8,190.00 |
| Нийт | | | | | | 432,082.00 | 286,720.00 | 145,362.00 |

## 12. Урьдчилсан байдлаар тооцсон усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ

| Ажлын нэр | Төлбөр тооцох усны хэмжээ, м3 | Усны ангилал | Хөнгөлөх хувь хэмжээ, % | 1 м3 усны үнэ | Усны нөөц ашигласны төлбөр, ₮ | Төлбөрөөс хөнгөлсөн дүн, ₮ | Төлбөл зохих дүн, ₮ |
|---|---|---|---|---|---|---|---|
| Худар боловсруулахад ашиглах усны хэмжээ | 122880.00 | Газрын доорх ус | 0.0 | 1646.40 | 202,309,632.00 | 0.0 | 202,309,632.00 |
| Үүрхайн өрөмдлөгт ашиглах усны хэмжээ | 8360.00 | Газрын доорх ус | 0.0 | 893.76 | 7,471,833.60 | 0.0 | 7,471,833.60 |
| Зам, талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ | 4032.00 | Газрын доорх ус | 0.0 | 188.16 | 758,661.12 | 0.0 | 758,661.12 |
| Биологийн нөхөн сэргээлтэд ашиглах усны хэмжээ | 900.00 | Газрын доорх ус | 0.0 | 70.56 | 63,504.00 | 0.0 | 63,504.00 |
| Тарбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан болон тарих модны арчилгаа, усалгаанд ашиглах усны хэмжээ | 1000.00 | Газрын доорх ус | 0.0 | 70.56 | 70,560.00 | 0.0 | 70,560.00 |
| Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ | 8190.00 | Газрын доорх ус | 0.0 | 70.56 | 577,886.40 | 0.0 | 577,886.40 |
| Нийт | 145,362.00 | | | | 211,252,077.12 | | 211,252,077.12 |

## 13. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар

- Ахуйн хэрэгцээнээс гарч буй бохир усыг стандартын шаардлагад нийцтэл цэвэршүүлэн эргүүлэн ашиглах.
- Нөхөн сэлбэлтээр авч ашиглах усны хэмжээг 30%-иас хэтрүүлэхгүй байх;

## 14. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө

- Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, зохих журмын дагуу гэрээ байгуулах;
- Хөвгдөл усны дүгнэлтийг дараа оны эхний улиралд багтаан гаргуулах;
- Усны тухай хуулийн 28.18-д заасаар ус ашиглуулах дүгнэлт; холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахгүй байх;

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

**УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ**
**№ ЭУ** 225170

Топ ган дриллинг -д
(хэрэглэгчийн нэр)
ашиглаж байгаа LXLG 100 загварын 60 м³/ц хэмжих хязгаартай, 100 мм-ийн голчтой № 211 0004965 -ын халуун, хүйтэн усны тоолуурыг № 017 лацаар битүүмжилж
(Тоолуур зурах)
2027 оны 03 -р сарын 07 -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 057761 м³

Лабораторийн тамга

Улсын шалгагчийн гарын үсэг, тамга

2025 оны 03 -р сарын 07 -ны өдөр

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

**УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ**
**№ ЭУ** 225168

Топ ган дриллинг -д
(хэрэглэгчийн нэр)
ашиглаж байгаа LXLC 80 загварын 40 м³/ц хэмжих хязгаартай, 80 мм-ийн голчтой № 202304263 -ын халуун, хүйтэн усны тоолуурыг № 017 лацаар битүүмжилж
(Тоолуур зурах)
2027 оны 03 -р сарын 07 -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 021561 м³

Лабораторийн тамга

Улсын шалгагчийн гарын үсэг, тамга

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

**УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ**
**№ ЭУ** 225169

Топ ган дриллинг -д
(хэрэглэгчийн нэр)
ашиглаж байгаа LXLC 100 загварын 60 м³/ц хэмжих хязгаартай, 100 мм-ийн голчтой № 202304304 -ын халуун, хүйтэн усны тоолуурыг № 017 лацаар битүүмжилж
(Тоолуур зурах)
2027 оны 03 -р сарын 07 -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 048527 м³

Лабораторийн тамга

Улсын шалгагчийн гарын үсэг, тамга

2025 оны 03 -р сарын 07 -ны өдөр

*Хавсралт 3 Тоолуур баталгаажуулалтын гэрчилгээ*

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Барилга, хот байгуулалтын сайдын
2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн
A/719/189 дүгээр тушаалын хавсралт

## ХАЯГДАЛ УС ХАЯХ, ЗАЙЛУУЛАХ

# ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар: 05

Засгийн газрын хэрэгжүүлэгч Усны газар -ын гаргасан
/ Дүгнэлт гаргасан байгууллага /

2022 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн хаягдал ус хаях, зайлуулах 73 тоот дүгнэлтийг үндэслэн Баянхонгор аймаг/нийслэл Галуут сум/дүүргийн Хүүшийн ам байршилтай
/ хаяг /

ашигт малтмал олборлох
/ үйл ажиллагааны чиглэл /

чиглэлээр хаягдал ус гаргаж байгаа “Индепендент голд майнинг” ХХК-д
/ Хүн, хуулийн этгээдийн нэр /

Баянхонгор аймаг/нийслэл, Галуут сум/дүүргийн Хүүшийн ам агд байршилтай хаягдал ус зайлуулах цэг буюу хүрээлэн буй орчинд болон төвлөрсөн бохир усны шугамд жилд 77.913 мян.м³ хаягдал усыг “Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 4943:2015”, “Хүрээлэн байгаа орчин, усны чанар, Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 6561:2015” стандартаар тогтоосон норматив шаардлагад нийцүүлэн хаях, зайлуулах зөвшөөрлийг
/ аль нь болохыг доогуур нь зурах /

нэг жилийн хугацаагаар олгож, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ болон дүгнэлтийг зөрчөөгүй тохиолдолд зөвшөөрлийг жил бүр сунгагдсанд тооцно. Хаягдал усны хэмжээ болон хаягдал ус зайлуулах цэг, төвлөрсөн бохир усны шугамын байршил өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр шинээр зөвшөөрөл олгоно.

Зөвшөөрлийн бичиг олгосон:

/ Зөвшөөрөл олгосон байгууллага / — / Гарын үсэг / — / Гарын үсгийн тайлал /

Тамга

2022 оны 06-р сарын 29-ны өдөр

СУНГАЛТ

| Сунгалт хийсэн шийдвэр | Огноо | Гарын үсэг, тамга |
|---|---|---|
| Усны газрын 2023 оны 03 сарын 27-ны өдрийн 42 дугаар дүгнэлт | 2023. 03. 30 | [signature] |
| Усны газрын 2024. 08. 16-ны Е-2407-000162 дүгнэлт | 2024. 09. 20 | [signature] |
| Усны газрын 2025. 04. 28-ны Е-2504-000306 дүгнэлт | 2025. 05.28 | [signature] |

*Хавсралт 4 Хаягдал усны зөвшөөрөл*

| БАТЛАВ | БАТЛАВ |
|---|---|
| БӨӨНЦАГААН-ОРОГ НУУРЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА Б.НЯМ-ОЧИР | ТОП ГАН ДРИЛЛИНГ ХХК-ИЙ УУРХАЙН ДАРГА П.ГАН-ЭРДЭНЭ |

**ХАЯГДАЛ УСЫГ БАЙГАЛЬД ШУУД НИЙЛҮҮЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ БАЙГУУЛАХ УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ**

2025 оны 05 дугаар сарын 28р Дугаар 06 Номгон

**Нэг. Ерөнхий зүйл**

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйл, 24.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын даргын 2025 оны 04 дугаар сарын 28-ны өдрийн Е-2504-000306 дугаартай хаягдал усны дүгнэлт, Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны даргын гаргасан 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/18 дугаартай хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг үндэслэн нэг талаас ус ашиглуулагчийг төлөөлж Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны усны чанар, экологи, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Энхтогтох, нөгөө талаас: ус бохирдуулагчийг төлөөлж улсын бүртгэлийн дугаар:9011720069, регистрийн дугаар:6268048, “Топ ган дриллинг” ХХК-ны уулын төлөвлөлтийн инжинер Л.Чинзориг нар ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөр төлөх талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг 2025 оны 12 дугаар сарын 10 хүртэлх хугацаатай байгуулав.

**Хоёр. Гэрээний гол нөхцөл**

2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага” MNS 4943:2015 стандартын норматив шаардлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.

2.2. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлсэн тохиолдолд ус бохирдуулсны төлбөр, стандартын норматив шаардлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуулсны нөхөн төлбөрийг хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээнээс хамааран 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлнө.

2.3. Төлбөр төлөгч нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөр, нөхөн төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлнө.

*Хавсралт 5 Хаягдал усны дүгнэлт*

БАТЛАВ.

"ЧАНДМАНЬ БАЯНХОНГОР" ХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.СОРОНЗОНБААТАР

БОХИР УС ТАТАН ЗАЙЛУУЛАХАД
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

№ ГА/2025/07

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

1.1. Энэхүү гэрээг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 26 дугаар зүйл, хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 13.14-р зүйлийг үндэслэн нэг талаас 2605791 регистртэй Чандмань Баянхонгор ХК /түүнийг төлөөлж борлуулалтын менежир С.Лхавгасүрэн /цаашид гүйцэтгэгч тал гэх/, нөгөө талаас 6268048 регистртэй Топ Ган Дриллинг ХХК /цаашид захиалагч тал гэх/ бид харилцан тохиролцож 2025 оны 05 дугаар сарын 30-ний өдөр байгуулав.

1.2. Энэхүү гэрээний зорилго нь Баянхонгор аймгийн Галуут сумын Сүмбэр 2-р багийн "Хүүшийн ам уурхай" "Чандмань Баянхонгор" ХХК-ийн хооронд байгуулсан ахуйн бохир нийлүүлэх гэрээний дагуу уурхайн бохирыг төв бохирын хоолойруу нийлүүлэх Топ Ган Дриллинг ХХК өөрийн эзэмшлийн бохир соруулах тусгай зориулалтын автомашинаар ариун цэврийн байгууламжаас бохир усыг татан зайлуулж "Чандмань Баянхонгор" ХХК-ийн цэвэрлэх байгууламжид нийлүүлэх ажил гүйцэтгэх /цаашид "Ажил" гэх/ тэдгээртэй холбоотой үүсэх харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль болон бусад хууль, дүрэм, журмын дагуу зохицуулахад оршино.

**ХОЁР. ТӨЛБӨР**

2.1. Цэвэрлэх байгууламжид нэг удаагийн бохир усыг зайлуулах төлбөр 150,000 /Зуун тавин мянган / төгрөг байна.
2.2. Дээрх гэрээний үнэнд НӨАТ болон шатахууны зардал багтсан болно.
2.3. Бохир соруулсан төлбөрийг нэхэмжлэлийн дагуу Хаан банкны 5225031142 тоот дансанд шилжүүлнэ.

**ГУРАВ. ХУГАЦАА**

3.1. Гэрээний хугацаа 2025 оны 05 дугаар сарын 30-ний өдрөөс 2027 оны 05 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд.
3.2. Гэрээний хугацаа дуусахад талууд гэрээг дүгнэн хугацааг сунгах асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

**ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ**

4.1. Байгаль орчин бохирдуулахгүй, хүн, мал, амьтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхгүй, эдгээртэй холбоотой хууль, дүрэм, журмуудыг зөрчихгүйгээр чанар, стандарт шаардлага хангаж ажлыг гүйцэтгэнэ.
4.2. Байгууламжид ажил гүйцэтгэсэнтэй холбоотой гарсан аливаа зөрчил маргаантай асуудлыг /байгаль орчин бохирдуулсан, хүн, мал, амьтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөн гэх мэт/ бүрэн хариуцана.
4.3. Ажил гүйцэтгэх үед Замын хөдөлгөөний дүрмийг чанд баримтлан аюулгүй байдлыг хангана.
4.4. Ажлыг өөрийн зардлаар гүйцэтгэж Маягт 1-ийн дагуу баримт үйлдэж баталгаажуулан нэхэмжлэхийн хамт захиалагчид хүргэнэ.

*Хавсралт 6 Ахуйн бохир нийлүүлэх гэрээ*

| | |
|---|---|
| БАТЛАВ<br>ЦЭВЭР ХОТ ОНӨ ААТҮГАЗРЫН ЗАХИРАЛ П.УРТНАСАН<br>2025 оны 05 сарын 05 | БАТЛАВ.<br>"ТОП ГАН ДРИЛЛИНГ ХХК" УУРХАЙН ДАРГА П.ГАН-ЭРДЭНЭ<br>2025 оны 05 сарын 05 |

**ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ**

**№ 345**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Гэрээний зорилго: Ахуйн болон үйлдвэрлэлийн ангилсан хог хаягдлыг цуглуулж ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэж ажиллах талаар иргэн, байгууллага, аж ахуйн нэгжтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажил гүйцэтгэх гэрээг байгуулах, хэрэгжүүлэх, дүгнэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэхүү гэрээний эрх зүйн үндэслэл нь Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйл, Зөрчлийн тухай хуулийн 6.16 дугаар зүйл, Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг шинэчлэн тогтоох тухай Баянхонгор сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны 12/73 тогтоолыг тус тус үндэслэнэ.

1.3. Энэхүү гэрээний хэрэгжилтэд тухайн байгууллагын удирдах ажилтнууд болон сумын Засаг дарга, ажлын алба, хөндлөнгийн хяналтын байгууллага, хууль журам гэрээгээр тохирсон хэм хэмжээнд хяналт тавина.

1.4. Хог хаягдлыг ангилан ялгах байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах.

**Хоёр.Гэрээ байгуулагч талууд**

2.1. Гэрээг нэг талаас "Цэвэр хот ОНӨААТҮГ"-ыг төлөөлж цаашид "тээвэрлэгч гэх" орлогын байцаагч ажилтай М.Алимаа нөгөө талаас "Тээвэрлүүлэгч гэх" "Топ ган дриллинг ХХК "-ийг төлөөлж ....П.Ган-Эрдэнэ.... нар харилцан тохиролцон энэхүү гэрээг байгуулав.

**Гурав. Тээвэрлэгчийн эрх үүрэг**

3.1.Хог хаягдлын хэмжээг Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 07 сарын 19-ний өдрийн 191, А/243 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцох аргачлалын дагуу тооцож, төлбөр хураамжийн үнийн тарифыг тогтоож Баянхонгор сумын ИТХ-аар батлуулсан байна.

3.2. Хог хаягдал тээвэрлэх чиглэл, хуваарийг тогтоож Баянхонгор Сумын Засаг даргаар батлуулан мөрдөж ажиллана.

3.3.Баянхонгор сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшил, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг тогтоосон хуваарийн дагуу зориулалтын тээврийн хэрэгслээр ачиж тээвэрлэн нэгдсэн хогийн цэгт хүргэн дарж булшлах, хог хаягдлын түрэлтийн үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

3.4.Барилгын болон хортой, тусгай хог хаягдлыг холбогдох журмын дагуу тээвэрлэнэ.

3.5.Төрийн байгууллага, иргэн, аж ахуй нэгж, хувийн хэвшилүүдийн хог хаягдлыг хуваарийн дагуу тогтмолоор ачиж тээвэрлэнэ.

3.6.Гүйцэтгэгч нь ажил үйлчилгээ үзүүлсэн төлбөрийг нэхэмжлэх, заасан хугацаанд төлөхийг шаардах эрхтэй \Зөрчлийн тухай хуулийн 6.16 дугаар зүйл заалт\

3.7. Тухайн байгууллага, аж ахуй нэгж, хувийн хэвшил, иргэн хог хаягдлын төлбөр тооцоо хийгдээгүй тохиолдол хог хаягдлыг тээвэрлэхгүй ба түүнээс гарсан асуудлыг Цэвэр хот ОНӨААТҮГазар хариуцахгүй болно.

3.8.Хог хаягдлыг тээвэрлэх тээврийн хэрэгсэл буюу авто машинууд нь зориулалтын битүүмжлэлтэй аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

3.9 Нэгдсэн хогийн цэгт иргэн аж ахуй нэгж байгууллага нь ахуйн хог, барилгын хог, болон мал амьтны гаралтай хог хаягдлыг асгасан тохиолдол тус байгууллагад түрэлтийн төлбөрийг Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг шинэчлэн тогтоох тухай Баянхонгор сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны 12/73 тогтоолыг дагуу төлнө.

**Дөрөв. Тээвэрлүүлэгчийн эрх, үүрэг**

*Хавсралт 7 Хог хаягдал гэрээ*

4.1 Хог тээврийн гэрээний төсөлтэй танилцаж, хог хаягдлын тухай хуулийн 10.2.3-т заасны дагуу гэрээ байгуулах

4.2.Гэрээний дагуу хог хаягдлаа сардаа тогтмолоор хуваарийн дагуу ачуулах

4.3 ХХТХ-ийн 10.2.2-т заасны дагуу хог хаягдлыг түр хадгалах савны стандартыг хангасан хогийн савтай байх /галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тундасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн/, ХХТХ-ийн 10.2.1-т заасны дагуу ангилан ялгах

4.4 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг ХХТХ-ийн 10.2.7-т заасны дагуу тогтоосон хугацаанд төлөх

4.5 Тухайн аж ахуйн нэгж, байгууллага, орчин тойрныхоо 50-100 метр хүртэлх зайг цэвэрлэж тээвэрлүүлэх.

4.6 Нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох, хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх

4.7 Хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаяхыг хориглоно

4.8 Нийтийн эдэлбэр газар, ногоон бүсэд хог хаяхыг хориглоно

4.9 Хог хаягдлыг ил задгай шатаахыг хориглоно

4.10 Дээрх зүйл заалтуудыг зөрчсөн тохиолдолд зөрчлийн тухай хуулийн 6.16 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээнэ.

4.11 Хог хаягдлын үйлчилгээтэй холбоотой санал гомдлыг 7044-4200, 90104200 утсаар мэдээллэнэ.

**Тав.Төлбөрийн нөхцөл**

5.1 Хог хаягдлын тухай хуулийн 41.1 дүгээр зүйл заалтыг үндэслэн хог хаягдал тээвэрлүүлэлтийн хураамжийг \Баянхонгор сумын иргэдийн хурлын 2023.12.18 12\73 тогтоолоор батлагдсан төлбөрийн хэмжээгээр **ахуйн хог 40000, аюултай хог 40000** төгрөгийг Төрийн сангийн данс болох 100032000947 тоот дансанд сар бүрийн 28-ны дотор тогтмол тушаана.

**Зургаа. Гэрээний хугацаа**

6.1 Гэрээ нь 2025 оны 05 сарын 05-ны өдрөөс 2025 оны 12 сарын 31-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

6.2 Гэрээний хугацаа дуусгавар болохоос ажлын 10 хоногийн өмнө тээвэрлүүлэгч талаас гэрээг сунгах хүсэлт ирүүлээгүй тохиолдолд гэрээг хүчингүйд тооцож хог тээвэрлэлтийг бүрэн зогсооно.

6.3 Холбогдох байгууллагууд үйл ажиллагаагаа бүр мөсөн зогсоосон нь нотлогдсон тохиолдолд уг гэрээг дуусгавар болсонд тооцно.

**Долоо. Талуудын хариуцлага, маргаан шийдвэрлэх журам**

7.1 Талууд хагас бүтэн жилээр гэрээний биелэлтийг дүгнэж, цаашид илүү үр дүнтэй хамтран ажиллах боломжийг тодорхойлж тооцоо нийлнэ.

7.2 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хог хаягдлын тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан зүйл заалтын дагуу хариуцлага хүлээнэ.

7.3 Энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд зөвшилцлийн замаар шийдвэрлэх бөгөөд шийдвэрлэх боломжгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

**Найм. Бусад**

8.1 Гэрээ нь талууд батлаж, гарын үсэг зурж тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

8.2 Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Гэрээний нэмэлт өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

8.3 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд нэг хувийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нөгөө хувийг нь тус байгууллага хадгална.

| | |
|---|---|
| ТЭЭВЭРЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ: | ТЭЭВЭРЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ: |
| ЦЭВЭР ХОТ ОНӨААТҮГ-Г | "ТОП ГАН ДРИЛЛИНГ ХХК УУРХАЙН ДАРГА |
| ТӨЛӨӨЛЖ ОРЛОГЫН БАЙЦААГЧ: М.АЛИМАА | П.ГАН-ЭРДЭНЭ |
| Хаяг: Номгон 1 дүгээр баг | Хаяг: ГАЛУУТ СУМ |
| Дөвөнтийн заалны 2 дугаар давхарт | Утас: 75579799, 99724440 |
| УТАС : 70444200, 90104200 | |

БАТЛАВ
"НОМГОН АРИУСАЛ" ХХК
ЗАХИРАЛ Б.ОЮУНГЭРЭЛ

БАТЛАВ
"ТОП ГАН ДРИЛЛИНГ"
ДАРГА Т.ГАН-ЭРДЭНЭ

**ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН ГЭРЭЭ**

Монгол улсын Иргэний хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал,Эрүүл ахуйн тухай хууль болон Ариутгал халдваргүйтгэлийн үйл ажиллагаатай холбогдох харилцааг зохицуулсан бусад хууль тогтоомжийг үндэслэн дараах нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг.Нийтлэг үндэслэл:

1.1 Энэ гэрээний зорилго нь Топ ган дриллинг-ийн захиалгаар Номгон- ариусал"ХХК нь: Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдварт өвчин үүсгэгчийг: тээгч, дамжуулагч, тараагч, ахуйн хортон шавж мэрэгчийг устгах хянах үйлчилгээг үзүүлэхтэй холбогдон үүсэх харилцаа болон талуудын эрх зүйн байдлыг тогтоож зохицуулахад чиглэгдэнэ./Хор бодис нийлүүлэх/

1.2 Талуудын баталгаажуулсан гэрээний хавсралт нь гэрээний салшгүй хэсэг болох ба үндсэн гэрээний нэгэн адил хууль зүйн хүчинтэй.

1.3 Энэ гэрээнд заасан дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.3.1 "Шавж"гэдгийг бүх төрлийн жоом,бэлцэгнүүр, аалз, шоргоолжийг:

1.3.2 "Мэрэгч" :гэдгийг бүх төрлийн хулгана хархыг

1.3.3 "Устгалын үйлчилгээ" гэдгийг нь мэрэгчийн тархалттай тохиолдолд үйлчилгээний эхний 45 хүртэлх хоногийн үйлчилгээг хэлэх бөгөөд үйлчилгээний зорилго нь шавж мэрэгчийн тархалтыг 90% иас дээш бууруулахыг:

1.3.4 "Хяналтын үйлчилгээ" гэдгийг шавж мэрэгчийн тархалтгүй тоиолдолд эсвэл устгалын үйлчилгээний дараа шавж мэрэгчийг тархах эсвэл дахин тархахаас урьдчилан сэргийлэх илрүүлэн устгах үйлчилгээг

1.3.5"Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдгийг"Газар хөдлөлт, үер усны аюул үймээн самуун ,эрх бүхий байгууллагаас гаргасан хорио цээр " зэргийг тус тус ойлгоно.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

2.1 Эрх

2.1 1 Үйлчилгээг чанарын өндөр түвшинд эрүүл ахуйн .шаардлага хангасан аргачлалаар үзүүлэхийг шаардах

2.1.2 Шаардлагатай тохиолдолд гэрээний хуваарийг үл харгалзан үйлчилгээ үзүүлэгч талд мэдэгдэн үзлэг танталт судалгааг нэмэлтээр хийлгэн зохих үйлчилгээг авах

2.1.3.Устгалын үйлчилгээний үр дүн нь зорилгодоо хүрээгүй гэж үзвэл үйлчилгээг дахин үнэ төлбөргүй хийлгэх

2.1.4 Гэрээний үүргээ биелүүлэхийг ажил гүйцэтгэгч талаас шаардах,гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах,цуцлах саналыг хүргүүлж шийдвэрлүүлэх

2.1.5 Гүйцэтгэсэн ажлын чанар үр дүн хангалтгүй байсны улмаас хохирол учирсан бол үр дагаварыг арилгахыг шаардах,арилгуулах

2.2 Үүрэг

2.2.1 Шавж мэрэгчийн талаарх мэдээллийг ажил гүйцэтгэгч талд үнэн зөв мэдээлэх объектоо бүрэн танилцуулж бүдүүвч зургийг гаргаж өгөх,ажил гүйцэтгэгч талын үзлэгийн хуудас болон үйлчилгээний өмнөх ба дараахь ажлын арга хэмжээг хэрэгжүүлж баримтжуулна.

2.2.2 Үйлчилгээний чанарт дотоодын хяналт тавих үүрэг бүхий ажилтныг томилж ажил гүйцэтгэгчтэй хамтран ажиллах боломжийг хангах

2.2.3 Үйлчилгээ эхлэхээс өмнө тухайн объектод харшилтай хэт мэдрэг хүмүүсийн талаарх мэдээллийг ажил олгогчид өгөх

2.2.4 Талуудын харилцан тохиролцсон цагийн хуваарийн дагуу үйлчилгээг эхлүүлэх ажил гүйцэтгэгчийг үйлчилгээ үзүүлэхэд хүлээгдэл чирэгдэл үүсгэхгүй байх талаар шаардлагатай бүх арга хэмжээг авч,нөхцөлийг хангаж ажиллах

*Хавсралт 8 Ариутгал, халдваргүйжүүлэлтийн гэрээ*

| | |
|---|---|
| БАТЛАВ<br>НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН<br>ЗАХИРАЛ Д.БЯМБАСҮРЭН<br>2025 оны 09 дугаар сарын 22 | БАТЛАВ<br>ТОП ГАН ДРИЛЛИНГ ХХК<br>ДАРГА П.ГАН-ЭРДЭНЭ<br>.........оны........дугаар сарын........ |

**АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛЫН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

2025 оны 09 дугаар сарын 22 №.33 Баянхонгор

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Нэг талаас Баянхонгор аймгийн **НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ЗАХИРАЛ Д.БЯМБАСҮРЭН** /Цаашид гүйцэтгэгч гэх/, нөгөө талаас **ТОП ГАН ДРИЛЛИНГ ХХК ДАРГА П.ГАН-ЭРДЭНЭ** /Цаашид захиалагч гэх / нар Монгол Улсын Иргэний тухай хуулийн 476, 196 дугаар зүйл, Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн А/173 тоот тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн А/117 тушаал, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 49/А/118 хамтарсан тушаалыг үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 22-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31 хүртэлх хугацаанд дараах нөхцөлтэйгээр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**Хоёр. Талуудын эрх үүрэг, хариуцлага**

2.1. **Захиалагчийн эрх, үүрэг**

2.1.1. Нэгдсэн эмнэлгээр эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлаа тээвэрлүүлэх, халдваргүйжүүлэх эрхтэй.

2.1.2. Гэрээнд санал оруулах эрхтэй.

2.1.3.Эмнэлгийн байгууллагад мөрдөгдөж байгаа хог хаягдлын ангилан, ялгах зааврын дагуу ялгаж аюултай хог хаягдлын зориулалтын уут саванд хийсэн байна.

2.1.4. ЭМС-ын тушаалд заасны дагуу хог түр хадгалах байрандаа зааврын дагуу түр хадгалсан байна.

2.1.5. Аюултай хог хаягдлыг бүртгэлийн дэвтэрт жин хэмжээг бичиж гарын үсэг зурж хүлээлгэн өгнө.

2.1.6. Тухайн эмнэлгээс аюултай хог хаягдалыг бүртгэж, жинлэж, хүлээн авч зөөвөрлөж, халдваргүйжүүлж, тээвэрлэсний төлбөрийг зохих журмын дагуу гүйцэтгэгч талд төлөх үүрэгтэй.

2.1.7. Тухайн эрүүл мэндийн байгууллагаас 7 хоногийн 2,5 дахь өдрүүдэд 10-12 цагийн хооронд аюултай хог хаягдлыг тээвэрлэн ачина.

2.2. **Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

2.2.1 Нэгдсэн эмнэлэг нь захиалагч талд ЭМС-ын 2025 оны А/173, А/193 тоот тушаалын дагуу шаардлага тавих эрхтэй.

2.2.2 Аюултай хог хаягдлыг халдваргүйжүүлэх, түр хадгалах зориулалтын байртай байна.

2.2.3. Аюултай хог хаягдлыг халдваргүйжүүлэх автоклавтай, ажиллуулах мэргэжилтэнтэй байна.

2.2.4. Аюултай хог хаягдлыг зөөвөрлөж, тээвэрлэх зөвшөөрөл бүхий зориулалтын машинтай байна.

2.2:5. Машиндаа хог жинлэх жин, хог хийх зориулалтын сав, бүртгэж хүлээн авах бүртгэлтэй байна.

1.3.3 Үүсгэгч нь гэрээний тохиролцсон хугацаанд хаягдал тосыг хүлээлгэн өгөөгүй тохиолдолыг үүсгэхгүй байхад анхаарч, хоёр тал хариуцлагатай, шударга зарчмыг баримтлана.

1.3.4 "Гэрээний төлбөр"-г баримтжуулахад санхүүгийн болон хаягдалын тухай \3.4 заалт \тодорхойлох, 6.2.4-ийн дагуу бүх зохицуулалтыг хоёр тал хуулийн дагуу хэрэгжүүлнэ.

1.4 Талууд гэрээг цуцлах саналаа ажлын 10 хоногоос доошгүй хугацаанд нөгөө талдаа бичгээр мэдэгдэх бөгөөд шийдвэрийг хамтран гаргана.

1.5 Аль нэг талаас гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн буюу удаа дараа гэрээний үүргээ хангалттүй биелүүлсэн тохиолдолд гэрээг нэг талын санаачлагаар цуцалж болно.

**Гурав. Үнэ, төлбөрийн нөхцөл**

3.1 Үүсгэгчийн хүлээлгэн өгөх Хаягдал тосны үнэ нь 1 литр тутамд "0" төгрөг */Тэг төгрөг/* байна.

3.2 Хоёр тал Аюултай хог хаягдалын жагсаалтын 13-р бүлгийн хаягдалыг үнэлэх ёс зүйн ашиг сонирхол байхгүй байна.

3.3 Энэхүү гэрээний хугацаанд хэдэн удаа тээвэрлэлт хийхийг талууд тухай бүр харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

3.4 Хаягдал тосны шинжилгээний лабораторийн дүнг үндэслэн ус, механик хольцийн үлдэгдэлийн хэмжээг хаягдал тосны баримтын дүнгээс хасалт хийж хаягдал тос хүлээн авсан маягт А\21 05-р хавсралтаар *\Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн батлагдсан* бүртгэлд хөтөлнө.

3.5 Үүсгэгч нь "Топ Ган дриллинг" ХХК-ийн төслийн талбайд стандарт нормын дагуу хадгалж, цуглуулж,тээвэрлэн хүлээлгэн өгнө.

**Дөрөв. Хаягдал тос ачих, тээвэрлэх, хүлээлгэн өгөх, хүлээн авах**

4.1 Хоёр тал эрх бүхий байгууллагаас баталсан аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, савлах, түр байршуулах, тээвэрлэх аюулгүй болгох, хадгалах устгах журмыг дагаж мөрдөх;

4.2 Үүсгэгч нь өөрийн төслийн талбайгаас хаягдал тосыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, хүлээлгэн өгөх аюулгүй ажиллагааг бүрэн хариуцна.

4.3 Үүсгэгч нь төслийн талбайгаас хаягдал тосыг зориулалтын хуримтлуулсан ёмкость савнаас зориулалтын тээврийн машинд тээвэрлэх, тээврийн үйл ажиллагаа, түүнтэй холбогдох үйлчилгээний хөлсийг бүрэн хариуцна.

4.4 Талууд энэ гэрээний дагуу хаягдал тос хүлээн авах, хүлээлгэн өгөхдөө савны битүүмжлэлийг шалгаж, акт үйлдэн хүлээн авна. Актанд талуудын төлөөлөгчид гарын үсэг зурж 2 хувь үйлдэнэ.

4.5 Хэрэв хаягдал тос тээвэрлэх сав, хаягдал тосны үндсэн шинж чанарт бүрэн нийцэмжгүй, хэсэгчилсэн дээжинд химийн бодисын орц найрлагын шинж илэрсэн болон шинж чанарт тохироогүй үйлдэл байгаа болох нь тогтоогдвол Боловсруулагч нь хүлээн авахаас хэсэгчилэн болон бүхэлд нь татгалзах эрхтэй.

4.6 Талууд энэ гэрээний 4.1-т заасны дагуу шалгаж акт үйлдсэнээр хаягдал тостой холбоотой бүх эрсдэл Боловсруулагч талд шилжинэ. Боловсруулагч нь ийнхүү хүлээн авсанаас хойшхи үүсэх аливаа эрсдэлийг */ дахин боловсруулах бүх үе шатанд/* бүрэн хариуцна.

4.7 Үүсгэгч нь хаягдал тосны тээвэрлэлтийг гуравдагч этгээдээр хариуцуулан гүйцэтгүүлэх тохиолдолд энэхүү гэрээний бүх зүйл заалт нэгэн адил хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

**Тав. Үүсгэгчийн эрх, үүрэг**

5.1 **Үүсгэгч нь дараах үүрэгтэй:**

5.1.1 Хаягдал тосыг хүлээлгэн өгөхдөө гэрээний 4 дүгээр зүйлд заасны дагуу акт үйлдэн баталгаажуулж, Боловсруулагчийн төлөөлөгчөөр гарын үсэг зуруулж авах;

5.1.2 Хаягдал тосны хуримтлалын сав нь шингэн аюултай хаягдал хадгалах бүтээгдэхүүний стандартад нийцсэн, битүүмж алдагдаагүй газарт хадгалах;

5.1.3 Үүсгэгч нь Боловсруулагчид хаягдал тосны хуримтлагдсан тоо хэмжээг 5-7 хоногийн өмнө мэдэгдэж , тээвэрлэлт хийх хугацааг тогтоох;

5.1.4 Хаягдал тосыг хүлээлгэн өгөхдөө Боловсруулагчийн "Алтан Оршихуй групп" ХХК-ийн байгаль орчин, ХАБЭА-н шаардлагуудыг биелүүлэх;

5.1.5 Үүсгэгч нь Хууль болон гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлэх;

5.1.6 Үүсгэгч нь Боловсруулагчтай гэрээ байгуулснаас хойш өөр бусад этгээдэд хаягдал тос нийлүүлэхгүй байх, эсхүл өөрөө устгахгүй байх үүрэгтэй.

2

5.1.7 Боловсруулагчийн хэвийн үйл ажиллагаанд аль болох саад учруулахгүй байх нөхцөлийг сонгож ажиллах бөгөөд Боловсруулагчийн төслийн талбай, тусгай бүсэд хориглосон газар тамхи татах, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, хэрэглэсэн байдалтай нэвтрэх, эмх замбараагүй байдал үүсгэхийг ажилтнуудаа хориглох, тийм байдал үүсэхээс сэргийлж ажиллах;

5.2 **Үүсгэгч нь дараах эрхтэй:**

5.2.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;
5.2.2 Боловсруулагч талд санал хүсэлтээ мэдэгдэж шийдвэрлүүлэх;
5.2.3 Энэ гэрээний Хавсралт №1-т заасан цэгийг хүссэн тоогоор харилцан нэмэх;
5.2.4 Хууль болон гэрээнд заасан бусад эрх;

**Боловсруулагчийн үүрэг, эрх**

6.1 **Боловсруулагч нь дараах үүрэгтэй**:

6.1.1 Боловсруулагч нь хаягдал тосыг хүлээн авсанаар дүн шинжилгээ хийх, боловсруулах, устгах үйл ажиллагаа хариуцна.
6.1.2 Боловсруулагч нь гэрээний дагуу хүлээн авсан аюултай хог хаягдлыг устгах тохиолдолд тусгайлан бэлтгэсэн талбай, зориулалтын тоног төхөөрөмж, эсхүл байгууламж бүхий зөвшөөрөгдсөн цэгт аюулгүй болгон устгах;
6.1.3 Хаягдал тосыг дахин боловсруулахдаа хүрээлэн буй байгаль орчныг бохирдуулахгүй байхад шаардлагатай арга хэмжээг авч ажиллах;
6.1.4 Хаягдал тосыг Үүсгэгчийн мэдэгдсэн хугацаанд хүлээн авах, Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хоногийн хоцролт гарах үед тухай бүр урьдчилан мэдэгдэх; .

6.2 **Боловсруулагч нь дараах эрхтэй:**

**6.2.1 Санал хүсэлтээ Үүсгэгчид мэдэгдэж шийдвэрлүүлэх;**
**6.2.2 Үүсгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах.**
6.2.3 Үйлдвэрийн лабораторийн дүгнэлтийг үндэслэн механик хольц, усны хорогдолыг тооцон актад тусгана.
6.2.4 Учирсан хохирлоо үүсгэгчээс шаардах
6.2.5 Хууль болон гэрээнд заасан бусад эрх

**Долоо. Талуудын хүлээх хариуцлага**

7.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зохих журмын дагуу гүйцэтгээгүйгээс нөгөө талдаа хохирол учруулсан бол учирсан бодит хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй. Бодит хохирол гэдэгт хохирогч талд учирсан шууд хохирол болон түүний гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн хариуцлагыг ойлгоно.

7.2 Үүсгэгч нь Боловсруулагчид урьдчилан мэдэгдээгүйн улмаас техник тоног төхөөрөмжийг урьдчилан бэлтгээгүй, заавар зааварчилгаа аваагүй, хяналт тавиагүй, машин орох талбайг бэлтгээгүй, хүлээлгэн өгөхдөө хайхрамжгүй хандсан, хяналт сулруулсан улмаас гарах хохирлыг бүрэн хариуцна.

**Найм. Давагдашгүй хүчин зүйл**

8.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдэгт гэрээний талуудын хүсэл зоригоос гадуур гэрээний үүргийн гүйцэтгэлд саад болох хүчин зүйлийг ойлгоно. Энэхүү хүчин зүйл гэдэгт иргэний бослого, үймээн, зэвсэгт мөргөлдөөн, хорио цээр, үйлдвэрлэлийн талаарх засгийн газраас хэрэгжүүлэх арга хэмжээ болон байгалийн давагдашгүй хүчин зүйлс болох салхи шуурга, гал түймэр, газар хөдлөлт, үер зэрэг гамшигт нөхцөл байдал хамаарна. Энэхүү гэнэтийн болон давагдашгүй хүчний нөлөөллөөс болж талууд үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд тус хугацаагаар гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх хугацаа сунгагдах ба энэ тохиолдолд аль ч тал хариуцлага хүлээхгүй. Ийнхүү гэнэтийн болон давагдашгүй хүчний нөлөөлөл болсон гэдгийг талууд баримтаар баталгаажуулах үүрэгтэй.

8.2 Хэрэв Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс зохих ёсоор гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдалд орсон бол нөгөө талдаа нэн даруй мэдэгдэнэ.

**Ес. Маргаан шийдвэрлэх**

9.1 Энэхүү Гэрээг хэрэгжүүлэх явцад гэрээний үүргийн гүйцэтгэл болон хуулийн дагуу үүсч болох бүхий л үүргийн гүйцэтгэлтэй холбоотой аливаа маргааныг гэрээний талууд нэн тэргүүнд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

3

9.2 Талууд харилцан тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд Монгол улсын шүүхээр хянан шийдвэрлүүлнэ.

9.3 Энэ гэрээ нь Монгол Улсын хуулийн дагуу үйлдэгдсэн ба тэдгээр хуулийн хэм хэмжээнд тайлбарлагдан ойлгогдоно.

**Арав. Мэдээлэл хүргүүлэх**

10.1 Энэхүү гэрээтэй холбоотой аливаа мэдэгдэл, санал хүсэлтийг бичгэн хэлбэрээр, эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдэгтэйгээр үйлдэн доорх хаягаар хүргүүлнэ. Үүнд:

**Үүсгэгчид хүргүүлэх бол:**
Нэр: “Топ ган дриллинг” ХХК
Албан тушаал: Д.Гэрэлсайхан
Хаяг: MSN building 6 давхар 601 тоот.

10.1 дэх хэсэгт заасан мэдээлэлдээ өөрчлөлт оруулах бол нөгөө талдаа ажлын 10 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдээгүйгээс үүссэн аливаа хохирол, зардлыг мэдэгдээгүй тал нь бүрэн хариуцна.

**Арван нэг . Бусад зүйл**

11.1 Энэхүү Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

11.2 Энэхүү гэрээ хэрэгжих явцад гэрээнд аливаа нэмэлт өөрчлөлт оруулах, нэмэлт гэрээ байгуулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

11.3 Энэхүү Гэрээг Монгол хэл дээр бичгээр 1 хувь үйлдэх бөгөөд Үүсгэгчид 1 хувь, Боловсруулагчид 1 хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн ижил хүчинтэй байна.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

**Үүсгэгч талыг төлөөлж:**
“Топ ган дриллинг” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал
Холбогдох утас:
.............................

**Боловсруулагч талыг төлөөлж:**
“Алтан Оршихуй Групп” ХХК-ийн
Менежер Д.Ариунмөрөн
Холбогдох утас:91918550
.............................

4

........................................ тоот гэрээний Хавсралт №1

**Үүсгэгчийн талын харилцах албан тушаалтаны мэдээлэл**

| № | Албан тушаал | Овог нэр | Холбогдох утас | Е майл | Үйл ажиллагаа |
|---|---|---|---|---|---|
| 1. | ХАБ | [illegible] Мягмарсүрэн | 99724440 | myagmarsuren@gmail.com | Ачилтын хуваарь зохицуулах, дээж авч илгээх |
| 2. | | | | | |

**Боловсруулагчийн талын харилцах албан тушаалтаны мэдээлэл**

| № | Албан тушаал | Овог нэр | Холбогд утас | Е майл | Үйл ажиллагаа |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хангамжийн менежер | Д.Ариунмөрөн | 91918550 | Gug.ariunmoron@gmail.com | Ачилтын хуваарь зохицуулах Татаалт хийх |
| 2 | Нягтлан бодогч | М.Халиун | 98457888 | gug.haliun@gmail.com | |

**ХАВСРАЛТ БАТАЛСАН:**

**Үүсгэгч талыг төлөөлж:**
“Топ Ган Дриллинг” ХХК-ийн
[illegible]
Холбогдох утас:........ ..................

...........................................

**Боловсруулагч талыг төлөөлж:**
“Алтан Оршихуй Групп” ХХК-ийн
Менежер Д.Ариунмөрөн
Холбогдох утас:91918550

...........................................

5

*Хавсралт 9 Аюултай хог хаягдал нийлүүлэх гэрээ*